



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар A/543

Булган сум

Модон барилдааны Дэлхийн аваргын тэмцээнд
амжилттай оролцож, медальт байранд шалгарсан багш,
дасгалжуулагч, тамирчдад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам” батлах тухай А/377 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“MAS Wrestling”-ийн 7 дахь удаагийн Модон барилдааны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн амжилттай оролцож, медальт байранд шалгарсан тамирчдыг бэлтгэн оролцуулсан багш, дасгалжуулагч, тамирчдад хүндэтгэл үзүүлэхэд 1,350,000 (нэг сая гурван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



08 Аймаг Засаг даргын 2025 оны
А/543 дугаар сарын 11-ны/ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Модон барилдааны дэлхийн аваргын тэмцээнд амжилттай оролцож,
медальт байранд шалгарсан багш, дасгалжуулагч, тамирчдад
хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1.	Дасгалжуулагчид хүндэтгэл үзүүлэх С.Нэмин	1	500,000	500,000
2.	Дурсгалын зүйл /цэцэг/	5	70,000	350,000
3.	Тамирчин Б.Ариун-Эрдэнэ	1	500,000	500,000
Нийт дүн			1,350,000	